

## **ҮНДЭСНИЙ ЭРХ АШИГАА ШИНЭЭР ТОМЪЁОЛЖ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛАА ЭРГЭН ХАРАХ УУ?**

*К.Дэмбэрэл\**

Аливаа улс бүхэн өөрийн гэсэн эрх ашигтай, түүнийгээ хэр оновчтой, бодитой томъёолсон, хэрхэн хамгаалдаг, талаар уншсан, сонссон зүйлээ болон Монгол Улсын үндэсний эрх ашиг, аюулгүй байдлын бодлого ямар байвал монголчуудад маань ашигтай байж, улс орны хөгжилд нэмэртэй болох талаар хүмүүст бага ч атугай ойлголт хүргэх үүднээс саналаа нэмэрлэхийг зорилоо.

Бид нүүдэлчид, хэрвээ аюул учирвал нэг тийшээ арилж орхино гэсэн аюулгүй байдлын тухай өвөг дээдсийн маань хэвшмэл ойлголт хоёр талаараа “хашуулсан” үеэс л түүх болон үлдсэн.

“Үндэсний эрх ашиг” хэмээх ойлголтод зөвхөн “Монгол Улсын үндэсний эрх ашиг” гэсэн ойлголт хамаарна. Учир нь “дэлхийгээр нэг тархсан” монголчуудын эрх ашгийн талаар хөндөх нь илүүц биз. Үндэсний эрх ашиг гэж хэний эрх ашгийг хэлэх вэ?, түүнийг хэн, хэрхэн тодорхойлдог вэ? хэмээх зүйлүүд тодорхой хариултаа хүлээж л байгаа. Зарим хүмүүсийн хувьд төрийн өндөр албан тушаалтан, улс төрчдийн дэвшүүлсэн үндэсний эрх ашгийг тодорхойлолтын хамт хүлээн авч хэрэгжүүлэх ёстой гэсэн хувилбар ч бий.

Эрх ашиг гэдэг нь бодит шаардлагын илэрхийлэл төдийгүй хүний үйл ажиллагааг өдөөгч зүйл. Хүн томъёолдог тул уг чанартаа субъектив, хийсвэр зүйл. Эрх ашиг нь тодорхой бодлогод “сууж” өгснөөр зорилго болон хувирна. Үндэсний эрх ашиг нь бодит шаардлагад хэр нийцэж буй нь нийгэм, төрийн шинж чанар, улс төрийн хүчнүүдийн хүчний харьцаанаас ч хамаарна. Үндэсний эрх ашгийг олон улсын тавцан дээр хэн, ямар үүрэг, хариуцлагатайгаар хэрэгжүүлэх вэ? гэсэн асуудалд бид мөн анхаарах нь зүйтэй.

Үндэсний эрх ашгаа ихэнхи улсууд дараахи байдлаар тодорхойлдог. Үүнд: тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн байдал, улс төрийн эрх чөлөө, эдийн засгийн тогтвортой хөгжил. Эрх ашигаа цэгцтэй, зөв томъёолоод дээрхи эрх ашигт маань харшлаж буй болон харшлах зүйлүүдийг гаргаж тавих ба тэдгээрийг саармагжуулах боломжийг судлан хариу арга хэмжээ авдаг.

Үндэсний аюулгүй байдлын бодлого гэж байдаг, энэ бодлого нь үндэсний эрх ашгийг (улсын эрх ашиг гэж ч ойлгож болно) хамгаалах нэг л зорилготойгоор томъёологдох ёстой. Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрх ашигаа бид гаргаж тавих учиртай ба тэр эрх

\* К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

ашгийг аюулгүй байдлын бодлогоор хамгаалах, түүнд учирсан хохирол, учирч болзошгүй заналхийллийг тооцоолж сурах нь “хүн шиг” амьдрахын утга учир. Үндэсний аюулгүй байдлын бодлогод салбарын хууль, тогтоомж, дүрэм, журам төдийгүй гадаад бодлогын үзэл баримтлалаа ч “уяж” өгдөг нь нийтийн жишиг. Нэг ёсондоо үндэсний эрх ашигт нийцүүлэн хууль, дүрмээ гаргах нь нийтийн жишигт нийцнэ. Бид “жижиг улс” хамаагүй гэсэн ойлголт энд байхгүй.

Олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд, тухайлбал, НҮБ-ын дүрэм, Хельсинкийн акт зэрэгт аливаа улсын үндсэн болон түгээмэл эрх ашгуудыг тусгасан байдаг. Эдгээрт тухайн улсын оршин тогтнох, улс төрийн тусгаар байдал, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс үл оролцох, газар нутгийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын дархан байдал зэргээр томъёолсон. Түүнээс гадна аливаа улс бүрт өөрийн гэсэн өвөрмөц эрх ашиг гэж бий. Энэ нь тухайн улсын газар зүйн нөхцөл байдал, дотоод нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл, соёл уламжлал, зан заншил, иргэншлийн онцлогтой холбогдон үүснэ. Энэхүү өвөрмөц эрх ашиг нь цаг хугацаа, бодит хүчин зүйл, хөгжлийн явцад “дүр зургаа” өөрчлөх буюу үгүй болж харин шинэ “эрх ашгууд” жам ёсны дагуу гарч ирж болно.

Үндэсний эрх ашиг нь зайлшгүй “зуучлагчаар” дамжин илэрдэг зүйл. Манай нөхцөлд зуучлагч нь Улсын Их Хурал байх жишээтэй. Үндэсний эрх ашигт олон янзын “үйрмэг” (нам эвслийн, бизнесийн, санхүүгийн, нийгмийн давхаргуудын г.м.) эрх ашгууд багтдаг ба эдгээр нь үнэндээ “орон нутгийн чанартай асуудал” тул зөвхөн хэлэлцүүлгийн үе шатанд л дэлгэрүүлэнгүй авч үзэх шаардлагатай тул энд орхих нь зүйтэй гэж үзлээ.

Үндэсний эрх ашгийг хоёр бүлэг ойлголтод хуваан, нэгдүгээр бүлэгт хамрах буюу суурь ойлголтыг хэзээ ч үл хөндөх ба хоёрдугаар бүлгийн ойлголтуудыг нийгмийн тогтолцоо, хөгжлийн үе шат зэргээс хамаарч “гар хүрч” байхаар томъёолбол дээр юмуу даа.

Үндэсний эрх ашиг гэсэн асуудал яригдаж эхлээд 100 шахам жил болж буй ч нэгдмэл нэг ойлголтод өдий хүртэл хүрээгүй байгаа нь төвөгтэй ойлголт гэдгийг ч харуулж байна. Энэ ойлголтыг гүн ухаан, улс төр, эдийн засаг гэх мэтээр олон талаас нь олон байр сууринаас авч үзэж болдог. Үндэсний эрх ашигаа гадаад бодлогоороо хэрхэн хамгаалах вэ? гэдэг асуудал ч чухал байсаар ирсэн.

Ингээд судлаачдын байр суурь уг асуудлаар ямар байдгийг тандъя. Үндэсний эрх ашигт чухам юуг эн тэргүүнд тавих вэ? гэдэгт судлаачид өөр өөр байр суурьтай байсаар ирсэн. Зондерманы томъёолсон “нэг улсын үндэсний эрх ашиг нөгөө улсын үндэсний эрх ашигт нийцэж байх ёстой” гэсэн сонгодог хэмээн үзэж болохуйц томъёолол ч бий. Нэн ялангуяа, жижиг улсуудад илүү нийцтэй зүйл.

1934 онд түүхч Ч.Бирд нарын бичсэн “Үндэсний эрх ашгийн үзэл санаа” хэмээх бүтээл энэ чиглэлд анхных нь. Үндэсний эрх ашгийг нийгмийн

тогтолцооноос нь хамаарч династийн, төрийн сайн сайхны, ард түмний, ангийн гэх мэтээр ангилж ч байсан. А.Мэхэн, Р.Осгуд, Ж.Чейз, А.Жорж, Р.Кеохан зэрэг судлаачдын томъёолсон Үндэсний эрх ашиг нь ерөнхийдөө дараахи чиглэлүүд багтаж байна. Үүнд: газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, гадаад далайд хяналт тавьж байх боломжтой газар нутаг олж авах, улс төрийн хувьд тусгаар байх, төр засгийн үндсэн институцийг дэмжих, дайснуудаас цэргийн баазаа хамгаалах, хилийн чанадад өөрөө удирдах ёс, ардчиллыг дэмжих, худалдааг хамгаалж хөгжүүлэх, дэлхий дахинаа хүчний тэнцвэрийн хувьд таатай системийг бүрдүүлэхэд туслах, хүн хүссэн газраа амьдрах, эрх чөлөөтэй байх (төрөөр хамгаалуулах, засаглалын хэлбэрийг сонгох г.м), эдийн засгийн хувьд оршин тогтнох (эдийн засгаа өсгөн өргөжүүлж байх) гэх мэт. Үндэсний эрх ашигт “үнэт зүйлс” мэтийн үзэл суртлын ойлголтуудыг оруулах эсэх асуудал өдий хүртэл судлаачдын дунд маргааны сэдэв хэвээр байгаа. Г.Моргентау үндэсний эрх ашиг, “хүчний тэнцвэр” гэсэн хоёр ойлголтыг дүйцүүлж тавьсан байдаг.

**Үндэсний аюулгүй байдал гэж юу вэ?** Энэ нь ердөө үндэсний эрх ашгаа хамгаалах л стратеги. Бидний олонхи нь аюулгүй байдлыг зөвхөн буу, шийдэм агссан цэрэг, цөмийн зэвсэг, хорлон сүйтгэх ажиллагаа, алан хядах үйлдэл гэх мэтээр төсөөлж сэтгэж ирсэн. Энэ ойлголт хуучирсан хэдий ч бидний аюулгүй аж төрөхөд заналхийлдэг зүйлсийн зөвхөн нэг хэсэг. Бид аюулгүй байдлын асуудлаар дэндүү хийсвэр ойлголттой явж ирсэн. Энэ улгаараа уг ойлголтыг хийсвэр ч томъёолсоор байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал бол бодлогын чанартай баримт бичиг байх ёстой. Харин манай өнөөгийн “үзэл баримтлал” гэсэн баримт бичиг маань “бодлогын бус” харин ямар нэгэн Засгийн газрын мөрийн хөтөлбөр, эсвэл хууль ч юм уу, лоозунг ч гэмээр томъёологдсон байх юм.

Ингээд зарим улсууд үндэсний аюулгүй байдлын бодлогоо хэрхэн тодорхойлсныг авч үзье.

АНУ-ын “Үндэсний аюулгүй байдлын стратеги” баримт бичигт үндэсний эрх ашгийг “амин чухал” эрх ашиг, “чухал” эрх ашиг, “хүмүүнлэнгийн болон бусад” эрх ашиг хэмээн 3 үндсэн ангилалд хуваагаад “амин чухал” эрх ашгийг хангахад шаардлагатай гэж үзвэл дангаараа цэргийн хүчийг хэрэглэхээр заасан. “Чухал” эрх ашигт АНУ-ын сайн сайхан байдал, хөгжил дэвшил, эдийн засгийн ашиг сонирхол, холбоотны өмнө хүлээсэн үүрэг зэргийг багтаадаг. “Бусад” хэмээх эрх ашигт ардчилал, хүний эрхийн үзэл санааг дэлхий дахинаа түгээн дэлгэрүүлэх гэх мэтийн зүйлсийг багтаажээ. Жил бүр батлагддаг “Төрийн департаментын стратегийн төлөвлөгөө” нь чухамхүү дээрхи эрх ашгийг хэрэгжүүлэх “бизнес-төлөвлөгөө” нь юм.

АНУ-ын хувьд дээрхи “амин чухал” эрх ашгаас гадна, 12 “онцгой чухал” эрх ашиг (дэлхийн чухал бүс нутаг дахь мөргөлдөөнийг таслан

зогсоох, зайлуулах, АНУ руу чиглэсэн хяналтгүй цагаачлалыг зогсоох гэх мэт), 11 “чухал” эрх ашиг (хүний эрхийг зөрчих асуудлыг зогсоох гэх мэт), 5 “орхигдуулж болохгүй” эрх ашиг (худалдааны тэнцвэртэй бус байдлыг болиулах, бусад улсуудад ардчиллыг өргөжүүлэх г.м.). Эдгээр 28 эрх ашгийг ерөнхийд нь “чухал” эрх ашгууд хэмээн багцалдаг. Өөрөөр хэлбэл, АНУ-ын эрх ашиг нь 5 “амин чухал”, 28 “чухал” эрх ашигт багтаж байна гэсэн судлаачдын нарийвчилсан дүгнэлт ч бий.

Үндэсний аюулгүй байдлын асуудлаар ОХУ-ын хувьд “Орос улс дэлхийн хамтын нийгэмлэгт”, “Орос улсын үндэсний эрх ашиг”, “ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын заналхийллүүд”, “ОХУ-ын үндэсний аюулгүй байдлыг хангах” гэсэн 4 бүлэгтэй баримт бичиг бий. Түүнийг нь “ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын концепци” хэмээн тунхагласан. Оросын зарим судлаачдын үзэж буйгаар энэхүү аюулгүй байдлын концепци нь найруулга талаасаа ч, агуулга талаасаа ч Орос шиг олон үндэстний, “асуудал” ихтэй улсад “тохирохгүй” аж. Бидний хувьд дэлхийн бодлогод тодорхой байр суурьтай энэ улсын аюулгүй байдлын концепцийг зөв үү, буруу юу гэх нь илүүц боловч энэ улс үндэсний эрх ашигаа хэрхэн томъёолж бодлогоо хааш нь хандуулах вэ гэдэг нь чухал зүйл.

Судлаачийн хувьд бодоход БНХАУ нь үндэсний эрх ашигаа дараахи хэлбэрээр томъёолох болов уу. Үүнд: одоо байгаа нийгмийн байгууламжийг хадгалах, улс орноо задраахгүйгээр бүрэн бүтэн байдлаа сахин хамгаалах гэх мэт.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь үндсэн 11 зүйлтэй бараг үндсэн хуультай “өрсөлдөхүйц” том хэмжээний баримт бичиг. Бид үндсэн хууль зөрчлөө хэмээн “өдөр бүр” л “шүүхдэлцэж” байна. Харин Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын энэ олон зүйл ангиуд яаж зөрчигдөж байгааг харамсалтай нь нэг их анхаарахгүй юм. Хэдийгээр Оросын концепци манайхаас 3 жилийн хожуу “төрсөн” ч манай үзэл баримтлалууд агуулга нэлээд төстэй. Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, Монголын “амин чухал” эрх ашиг зэрэгт уялдуулан үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа шинээр томъёолж, түүнд “хариуцлагатай” хандах үүрэг хүн бүрт ногдож байна.

Үндэсний аюулгүй байдлын бодлогод “хоёр зүйл л чухал байсаар ирсэн нь нэгдүгээрт, дайсан, хоёрдугаарт холбоотон” хэмээн зарим сэтгэгчид тодорхойлсон байдаг.

Эдийн засгийн аюулгүй байдлын талаархи ойлголт жирийн хүмүүсийн дунд төдийгүй судлаачдын дунд “төөрөгдөл” чирсэн ойлголт хэвээр байна. Үндэстэн дамнасан корпораци, үндэсний хөрөнгөтнүүд, хувийн хөрөнгө нь зарим улсуудын ДНБ-ээс давчихсан хүмүүсийн асуудал гээд үндэсний эрх ашиг, аюулгүй байдлыг томъёолоход “толгойн өвчин” болсон зүйлүүд нэмэгдсээр байна.

Ихэнхи улсууд олон нийтийн аюулгүй байдалд тэргүүн зэргийн ач холбогдол өгдөг. Учир нь олон нийтийн аюулгүй байдалд төр, засаг нь эхний ээлжинд хариуцлага хүлээдэг. Манайд олон нийтийн аюулгүй байдал гэхээр дээрэм, тонуул, зодоон цохион, осол аваар мэтийг шууд тусгаж ойлгодог бол бусад улсуудад үүнийг илүү өргөн утгаар, тухайлбал, ажилгүйдэл, байнгын орлогоо алдах, гэр бүл салаалт, хүчирхийлэл, архидалт, мөрийтэй тоглоом, гамшиг, бага цалин хөлс, эрүүл мэндээр хохирох зэргийг оруулж томъёолдог.

Хөгжилтэй улс орнуудад технологийн аюулгүй байдал гэдэг ойлголт бий. Үүндээ анхаарал ч их тавьдаг, хөрөнгө ч их зардаг. Дэлхийн 50 гаруй улс технологийн хулгай хийдэг гэсэн “дансанд” бүртгэгдсэн. Нэг ёсондоо нөгөө улсынхаа технологийн аюулгүй байдалд заналхийлсэн гэсэн үг.

Өнөөдөр Монгол Улсыг хэрхэн хөгжүүлэх вэ гэсэн асуудалд монгол хүн бүр л санаа тавьж байна. Магадгүй, цорын ганц гэж хэлж болох хөгжлийн гарц бол “хуучин ч” хамаагүй технологи эзэмших, шинэ технологи бий болгох явдал. Технологийг жижиг ч гэлтгүй л “олох” нь чухал байна. Бүр болдоггүй юмаа гэхэд дээрхи 50 улсын нэгэнд ч гэсэн багтаад л технологи олох аянд мордоцгооё. Ямар нэг технологи эзэмшсэн, ойлгодог хүн амьдралдаа “өөрийн” гэсэн бодолтой хандана. Энэ хандлага нь бидний хөгжлийн нэг алхам. Монголчууд бид гадны тийм ч бараа бүтээгдэхүүн оруулж ирлээ хэмээн уралдахын оронд “тийм технологи хулгайлж” ирлээ гэдэг “моод” дэлгэрүүлэх нь хөгжилд тустай. Монгол Улсад хэдийчээн их гадны мэргэжилтэн, хэдийчээн их техник, технологийн асуудлыг гадныхнаар шийдүүлж байна төдийчинээ манай аюулгүй байдалд заналхийлж байна гэж ойлгож болно. Газрын хөрсний бүхий л баялаг гарын салаагаар л урсаж байна гэсэн үг. Гэхдээ нэг өдөр бүх “сургагч” нараа хөөчих гэсэн үг биш шүү дээ.

### **Дүгнэлт**

Үндэсний чанартай баримт, бичиг боловсруулж гаргахдаа логик талаасаа ч, томъёолол, утга санааны талаасаа ч сайтар “ажиллах” шаардлага байна уу гэсэн бодлыг төрүүлж байна. Монгол Улсын хувьд амин чухал эрх ашиг гэвэл өнөөгийн дэлхий дахины “их давалгаанд” “тэсч үлдэх” гэсэн ганц л эрх ашиг бий. Тэсч үлдэхийн тулд бид тэсч үлдэх эрх ашигаа хэрэгжүүлэх урт хугацааны аюулгүй байдлын бодлогоо нийгмийн тэргүүлэх бүх хэсгийн оролцоотойгоор тун оновчтой зөв тодорхойлох ёстой болов уу.

Эцэст нь хэлэхэд, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь улс орны бодлогыг хөгжилд хандуулсан “залуур” нь байх ёстой болов уу.